



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 691

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд  
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 2.1, 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд хавсралтад заасны дагуу өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Улаанбаатар хотын даатгал” ХХК (М.Энхболд)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



1518001490

Санхүүгийн зохицуулах хорооны  
2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн  
691 дүгээр тогтоолын хавсралт



“УЛААНБААТАР ХОТЫН ДААТГАЛ” ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

(төгрөгөөр)

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эхний үлдэгдэл			Өөрчлөлт			Эцсийн үлдэгдэл		
		Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 100,000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг	Нэмэгдсэн	Хорогдсон	Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 100,000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь
1	Ц.Чинбат	32,468	3,246,800,000.00	64.9%	(32,468)		(3,246,800,000.00)			
2	С.Мөнгөнцэцэг							32,468	3,246,800,000.00	64.9%
3	М.Энхболд	17,132	1,713,200,000.00	34.3%				17,132	1,713,200,000.00	34.3%
4	Нийслэлийн өмчийн харилцааны газар	400	40,000,000.00	0.8%				400	40,000,000.00	0.8%
	<b>НИЙТ</b>	<b>50,000</b>	<b>5,000,000,000.00</b>	<b>100%</b>			<b>(3,246,800,000.00)</b>	<b>50,000</b>	<b>5,000,000,000.00</b>	<b>100%</b>